

*Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 72 тоот тогтоолын  
хавсралт*

*Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2011 оны 66 тоот тогтоолын  
хавсралт*

Бүсчлэлийн код болон шуудангийн нэгдсэн кодыг оноох,  
мэдээллийн санг бүрдүүлэх журам  
*(Хорооны 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 72 тоот тогтоолын хавсралтаар  
нэмэлт, өөрчлөлт оруулсан)*

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь бүсчлэлийн код болон шуудангийн нэгдсэн кодыг нийтэд хэрэглүүлэхтэй холбогдуулан бүсчлэлийн код болон шуудангийн нэгдсэн кодыг оноох, мэдээллийн санг бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, мэдээллийн санд өөрчлөлт оруулах харилцааг зохицуулахад оршино.  
*(Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)*

**Хоёр. НЭР ТОМЪЁО**

- 2.1. “Бүсчлэлийн код (зип код\*)” <sup>1</sup> гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн болон хот суурингийн хэсэг (бүс)-ийн байршлын тухай мэдээллийг агуулж, тэдгээрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулалт хийх боломж бүхий нөөцтэй 5 оронтой тоон илэрхийлэл.
- 2.2. “Шуудангийн нэгдсэн код”<sup>2</sup> гэж бүсчлэлийн кодоод суурилсан шуудангаар үйлчлүүлэгчийн байршлын хаягийг тоо буюу үсэг, тоо хосолсон хэлбэрээр илэрхийлсэн дээд тал нь 9 орон бүхий илэрхийлэл  
*(Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)*
- 2.3. “Мэдээллийн сан”<sup>1</sup> гэж бүсчлэлийн код, түүнтэй хамт хэрэглэгдэх шуудангийн хаягийн бусад бичвэр, байршлын зураглалыг багтаасан өгөгдлүүдийг цаашид өргөтгөх боломжтойгоор үүсгэсэн бааз.
- 2.4. “Хаягийн бүс”<sup>1</sup> гэж зорчих хэсэг буюу авто замаар тусгаарлагдсан үл хөдлөх объектод хамрагдах байгууллага, гэр болон орон сууцны нэг хороолол буюу түүнтэй ижил суурин хэсэг.

**Гурав. БҮСЧЛЭЛИЙН КОДЫГ ОНООХ**

- 3.1. Хүн амын суурьшилтай холбогдон шинээр хаягийн бүс үүсэхэд Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) “Шуудангийн тухай хууль”-ийн 9.1.3. дахь заалтын дагуу бүсчлэлийн кодыг онооно.  
*(Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан)*
- 3.2. Зохицуулах хороо нь шинээр үүсч буй хаягийн бүсэд бүсчлэлийн кодыг Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт болон орон нутгийн төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн сангийн хаягийн мэдээллийг үндэслэн тухайн бүсийн бүсчлэлийн кодын нөөцөд тулгуурлан онооно.  
*(Энэхүү заалтыг Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн)*

- 3.3 Зохицуулах хорооноос оноосон бүсчлэлийн кодын жагсаалтын дагуу “Шуудангийн тухай хууль”-ийн 7.1.4 дэх заалтыг үндэслэн шуудангийн нэгдсэн кодын жагсаалтыг жил бүрийн 1-р улиралд багтаан батлуулна.  
*(Энэхүү заалтын дугаарлалт Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн)*

Дөрөв. ШУУДАНГИЙН НЭГДСЭН КОДЫГ ОНООХ  
*(Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан)*

*(Хуучин байсан 4.1-4.3 заалтуудыг Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар хүчингүй болгосон)*

- 4.1 Зохицуулах хороо нь шуудангийн нэгдсэн кодыг оноохдоо бүсчлэлийн кодын мэдээллийн санд тулгуурлан онооно.  
*(Энэхүү заалтыг Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн)*
- 4.2 Шаардлагатай тохиолдолд шуудангийн нэгдсэн кодыг өөрчлөх, шинэчлэх асуудлыг Зохицуулах хороо нь Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт болон орон нутгийн төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагатай хамтран судалж шийдвэрлэнэ.  
*(Энэхүү заалтыг Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн)*

Тав. МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 5.1 Зохицуулах хороо нь Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт болон орон нутгийн төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны байгууллагын хаягжуулалтын мэдээллийг үндэслэн жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр нэгтгэн бүсчлэлийн кодын мэдээллийн санг бүрдүүлнэ.  
*(Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)*
- 5.2 Үндсэн сүлжээ эзэмшигч нь Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт хариуцсан болон орон нутгийн төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны байгууллагын хаягжуулалтын мэдээллийг үндэслэн жилд 2 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр нэгтгэн Шуудангийн нэгдсэн кодын мэдээллийн санг бүрдүүлнэ.  
*(Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн найруулсан)*
- 5.3 Зохицуулах хороо нь үндсэн сүлжээ эзэмшигчийн мэдээллийн санг үндэслэн бүсчлэлийн кодын мэдээллийн санд нэмэлт өөрчлөлтийг оруулна.
- 5.4 Мэдээллийн санг шаардлагатай төрийн захиргааны байгууллагуудад болон аж ахуйн нэгж, албан байгууллагуудад хэрэглүүлэх, нийтэд мэдээлэх, лавлахаар ашиглах ажлыг www.zipcode.mn сайт болон хэвлэмэл материалаар дамжуулан хүргэнэ.  
*(Хуучин байсан 5.5 заалтыг Хорооны 2015 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар хүчингүй болгосон)*

Зургаа. МЭДЭЭЛЛИЙН САНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 6.1. Мэдээллийн сангийн өгөгдөл дараах бүтэцтэй байна.
- Хаягийн бүсийн нэр, бүсчлэлийн код
  - Хаягийн бүсэд байрлах дүүрэг, гудамжны нэр

-Хаягийн бүсэд байрлах албан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, барилга байгууламжийн дугаар

6.2. Мэдээллийн сангаас хайлт хийхэд хялбар болгон өгөгдлүүдийг дор дурдсанаар төрөлжүүлнэ.

- Хаягийн бүсийн нэрээр буюу хот, гудамжны нэр, аймаг сум багийн нэрээр,

- Бүсчлэлийн кодоор,

- Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр, (тухайн хаягийн бүсэд байрлах төрийн захиргаа, аж ахуйн нэгж, албан байгууллагуудын

6.3. Мэдээллийн сангийн зураглалд дараах элементүүдийг харуулсан байна.

- Улаанбаатар хотод барилга байгууламж , гэр хороололын гудамж, зам талбайн байршил, хаягийн бүсийн хил, бүсчлэлийн код;

- Хөдөө орон нутагт аймаг, сум, багийн байршил хаягийн бүсийн хил, бүсчлэлийн код.

-----oO-----